



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/312

Сүхбаатар сум

Уралдаан зохион байгуулж,  
зардал гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", 29.1.6 "а", 29.2, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 2.1.6, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 2021 оныг "Чанарыг эрхэмлэх жил" болгох тухай захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2021 оныг "Чанарыг эрхэмлэх жил" болгон зарласантай холбогдуулан сурагчдын чанарын талаарх мэдлэгийг сорих, ач холбогдлыг ойлгуулах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх боломжийг бий болгож таниулах зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд "Чанарыг эрхэмлэх нь" сэдэвт гар зургийн уралдааныг зарлан зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Гар зургийн уралдааныг удирдамжийн дагуу зохион байгуулахыг аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга /Д.Ган-Отгон/-д даалгасугай.

3.Уралдааны шагналын зардалд зарцуулах 460.000 /дөрвөн зуун жаран мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.

4.Зарцуулсан хөрөнгийн тайланг холбогдох журмын дагуу гаргаж 2021 оны 11 дүгээр сарын 22-ны дотор тайлагнахыг аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга /Д.Ган-Отгон/-д даалгасугай



430910791

**“ЧАНАРЫГ ЭРХЭМЛЭХ НЬ” ГАР ЗУРГИЙН  
УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

**Нэг. Уралдааны зорилго:**

Сурагчдын чанарын талаарх мэдлэгийг сорих, ач холбогдлыг ойлгуулах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх боломжийг бий болгож таниулахад уралдааны зорилго оршино.

**Хоёр. Хамрах хүрээ:**

Сэлэнгэ аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчид

**Гурав. Хугацаа:**

Бүтээлийг 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 10-ны өдрийн 18:00 цаг хүртэл хүлээн авч, 11 дүгээр сарын 22-ны дотор шалгаруулна.

**Дөрөв. Сэдэв:**

“Чанарыг эрхэмлэх нь”

**Тав. Бүтээлд тавигдах шаардлага:**

- Бүтээлийн ард зургийн нэр
- Өөрийн овог нэр /Овог, нэрээ бүтэн бичих/
- Аймаг, сум, сургууль, ангиа бичих
- Төрсөн он, сар, өдөр, нас, хүйс бичих
- Шуудангийн хаяг, харилцах утас /өөрийн болон аав ээжийн утас байж болно/, гэрийн хаягаа зургийнхаа ард баруун доод өнцөгт гаргацтай цэвэр бичнэ.
- Зургийн хэмжээ А3 хэмжээтэй байх

**Зургаа. Шагнал, урамшуулал:**

1-р байр Өргөмжлөл, 150.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал

2-р байр Өргөмжлөл, 100.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал


3-р байр Өргөмжлөл, 50.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал

Тусгай байр, Өргөмжлөл болон дурсгалын зүйл

**Долоо. Бүтээл хүлээж авах хаяг, холбоо барих дугаар:**

Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс. [selenge@masm.gov.mn](mailto:selenge@masm.gov.mn), 99159540,  
99494174

Сэлэнгэ аймгийн Засаг даргын  
2021 оны 10 дүгээр сарын 21-ний өдрийн  
А/32 тоот захирамжийн 2 дугаар хавсралт



УРАЛДААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ /төг/
1	1-р байрны шагнал	1	150000	150000
2	2-р байрны шагнал	1	100000	100000
3	3-р байрны шагнал	1	50000	50000
4	Тусгай байр	2	30000	60000
5	Өргөмжлөл	5	20000	100000
Нийт				460000

ТӨСӨВ ЗОХИОСОН:

Д.ГАН-ОТГОН

ТӨСӨВ ХЯНАСАН:

Ж.ХИШИГДЭЛГЭР

Сэлэнгэ аймгийн Засаг даргын  
2021 оны 10 дүгээр сарын 21-ний өдрийн  
А/312 тоот захирамжийн 1 дүгээр хавсралт

## “ЧАНАРЫГ ЭРХЭМЛЭХ НЬ” ГАР ЗУРГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

### **Нэг. Уралдааны зорилго:**

Сурагчдын чанарын талаарх мэдлэгийг сорих, ач холбогдлыг ойлгуулах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх боломжийг бий болгож таниулахад уралдааны зорилго оршино.

### **Хоёр. Хамрах хүрээ:**

Сэлэнгэ аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчид

### **Гурав. Хугацаа:**

Бүтээлийг 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 10-ны өдрийн 18:00 цаг хүртэл хүлээн авч, 11 дүгээр сарын 22-ны дотор шалгаруулна.

### **Дөрөв. Сэдэв:**

“Чанарыг эрхэмлэх нь”

### **Тав. Бүтээлд тавигдах шаардлага:**

- Бүтээлийн ард зургийн нэр
- Өөрийн овог нэр /Овог, нэрээ бүтэн бичих/
- Аймаг, сум, сургууль, ангиа бичих
- Төрсөн он, сар, өдөр, нас, хүйс бичих
- Шуудангийн хаяг, харилцах утас /өөрийн болон аав ээжийн утас байж болно/, гэрийн хаягаа зургийнхаа ард баруун доод өнцөгт гаргацтай цэвэр бичнэ.
- Зургийн хэмжээ А3 хэмжээтэй байх

### **Зургаа. Шагнал, урамшуулал:**

1-р байр Өргөмжлөл, 150.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал

2-р байр Өргөмжлөл, 100.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал

3-р байр Өргөмжлөл, 50.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал

Тусгай байр, Өргөмжлөл болон дурсгалын зүйл

### **Долоо. Бүтээл хүлээж авах хаяг, холбоо барих дугаар:**

Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс. [selenge@masm.gov.mn](mailto:selenge@masm.gov.mn), 99159540,  
99494174

Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар,  
Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Боловсролын газар